



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.18 № 188

танай _____-ны № _____-т

“НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ч.РЭГЗМАА ТАНАА

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн”
ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 16 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХ-ОЧИР



002030093

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/27/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

“Лидер экаунт аудит” ХХК-ийн

Захирал: П.Шаравхорол

Утас:77114519 Цахим хаяг: sharav_8054@yahoo.com

“Лидер экаунт аудит” ХХК-ийн

Ахлах аудитор: Д.Лхамсүрэн

Утас: 99980079 Цахим хаяг:

Lhama_0324@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.18 № 189
танай _____-ны № _____-т

“НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ч.РЭГЗМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.МӨНХ-ОЧИР

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗД	Засаг дарга
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6-7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал	10
3.1. Балансын данстай холбоотой асуудал	10
3.1.1. Илрүүлэлт	10
3.1.2. Эрсдэл	10
3.1.3. Өгсөн зөвлөмж	10
3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	10-11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	133
4.3. Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.4. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга Ч.Рэгзмаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн балансын данстай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд НТАГ-тай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн аудит хийлээ.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 15-наас 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Лидер экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг “Лидер экаунт аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/60 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүний амьдрах, ажиллах таатай нөхцлийг бүх талаар бүрдүүлсэн, нүүдлийн болон суурин соёл иргэншлийн дэвшилттэй ололтуудыг харилцан шүтэлцээтэй уялдуулсан, үндэсний зан заншил, уламжлалыг хадгалсан орчин үеийн хотыг олон нийтийн оролцоотой төлөвлөх болон энэ чиглэлийн мэдээллээр хэрэглэгчдэд нээлттэй үйлчлэхэд оршино.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ, судалгаанд үндэслэн нийслэлийн хөгжлийн хэтийн чиглэлийг тодорхойлох, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан зураг төсөл болон бусад зураг төслийн баримт бичгийг иж бүрэн боловсруулах.
- Нийслэлийн хөгжлийн хэтийн чиглэлийг тодорхойлох ажлын хүрээнд бүс нутгийн хөгжлийн төсөл, нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө түүний тодотгол, шинэчлэл, дагуул хот тосгодын ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах.
- Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам гүүрийн зураг төсөл боловсруулах.
- Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй хот байгуулалтын төсөл хөтөлбөр, ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах зорилгоор зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах.
- Эрдэм шинжилгээний суурь болон дагалдах судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулсны үндсэн дээр хэтийн болон ойрын хөгжлийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө, төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 7 дугаар сарын 4-ний 116 дугаар тогтоолоор “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг нь баталсан байна. Нийслэлийн ЗД-ын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны А/07 захирамжаар тус байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг баталжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 740,985.8 мянган төгрөгөөс тооцон 11,114.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2.0 хувь буюу 24,665.0 мянган төгрөгөөр тооцсон нь тайлангт оны үр дүнгийн тайлангийн нийт зардал нь төлөвлөлтийн үе шатны нийт зардлын дүнгээс нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 163,684.2 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, ын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	286,985.3	83,032.0	-203,953.3
Авлага	991,179.7	1,075,845.3	84,665.6
Бараа материал	32,630.9	34,418.8	1,787.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	17,500.0	-	-17,500.0
Үндсэн хөрөнгө	120,672.3	93,194.4	-27,477.9
Биет бус хөрөнгө	2,272.2	1,065.7	-1,206.5
Нийт хөрөнгийн дүн	1,451,240.4	1,287,556.2	-163,684.2
Өглөг	134,162.7	161,695.0	27,532.3
Урьдчилж орсон орлого	500.0	-	-500.0
Өр төлбөрийн дүн	134,662.7	161,695.0	27,032.3
Өмч: Төрийн	161,153.0	161,153.0	-
Хуримтлагдсан ашиг	1,155,424.7	964,708.2	-190,716.5
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,451,240.4	1,287,556.2	-163,684.2

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь зураг төсөл боловсруулах ажил багассанаас шалтгаалж, өнгөрсөн оны үлдэгдэл болон энэ оны орлогыг үйл ажиллагаандаа зарцуулсан.

Авлага дансны үлдэгдэл 84,665.6 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар өссөн нь зургийн ажлын үлдэгдэл санхүүжилт болон барилгын ажлын явцад хийх зохиогчийн хяналтын зардал, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний үлдэгдэл санхүүжилт олгогдоогүйтэй холбоотой байна. Дансны авлага 1,058,884.0 мянган төгрөг бөгөөд энэ нь нийт авлагын 98.4 хувийг эзэлж байна. Авлагын дотор “Одкон холдинг” ХХК-аас авах 105,738.1 мянган төгрөгийн зураг төсөл боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас авах 268,074.5 мянган төгрөгийн ажлын явцад хийх зохиогчийн хяналтын зардал, Барилгын хөгжлийн төвөөс авах 140,547.9 мянган төгрөгийн зохиогчийн хяналтын зардал, БСШУСЯамнаас 65,000.0 мянган төгрөгийн зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилт байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь зураг төслийн үйлдвэрлэлд зарцуулах бүх төрлийн материалыг худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайланд онд 5,528.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хуримтлагдсан элэгдлийн дүн 31,490.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. НӨАУГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/557 дугаар тушаалаар 12,670.6 мянган төгрөгийн хөрөнгийг актлаж данснаас хассан, 3,040.2 мянган төгрөгийн хөрөнгийг устгасан, 9,630.4 мянган төгрөгийн хөрөнгийг НӨАУГ-т шилжүүлжээ.

Биет бус хөрөнгө буурсан нь элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь татварын байгууллагад төлөх нэмэгдсэн өртгийн албан татварын өр байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 964,708.2 мянган төгрөг болж 190,716.5 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан ашиг буурснаас шалтгаалжээ.

2.9. Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

"Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн" ОНӨААТҮГ нь тайлант онд 1,058,335.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 1,233,251.5 мянган төгрөгийг зарцуулж, 176,639.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Орлого өмнөх оныхоос 532,250.3 мянган төгрөгөөр, зардал 311,820.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь НИТХ-ын 2019 оны 7 дугаар сарын 25-ны 116 дугаар тогтоол гартал тус газрын үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй байснаас Нийслэлийн ЗД-ын баталсан зорилтот түвшинд заагдсан 4 ажлаас 3 нь хэрэгжээгүйгээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	1,571,211.1	1,054,051.0	-517,160.1	67.1
Борлуулалтын өртөг	538,114.8	357,562.1	-180,552.7	66.4
Нийт ашиг /алдагдал/	1,033,096.3	696,488.9	-336,607.4	67.4
Бусад орлого	19,374.5	4,284.3	-15,090.2	22.1
Ерөнхий ба удирдлагын зардал	1,006,478.7	875,689.4	-130,789.3	87.0
Бусад зардал	478.7	-	-478.7	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	42,006.5	-176,639.3	-	-
Орлогын татварын зардал	14,345.3	246.6	-14,098.7	1.7
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	27,661.2	-176,885.9	-	-

Нийслэлийн ЗД-ын баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 532,250.1 мянган төгрөг буюу 33.2 хувиар тасарч, зардал 307,401.0 мянган төгрөгөөр буурсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 11,891.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилтийн 10 хувь болон барилгын ажлын явцад хийх захиалагчийн хяналтын зардал, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний үлдэгдэл санхүүжилтийн авлагыг холбогдох газруудаас авч авлагыг барагдуулсан талаарх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 88 мэдээллийг хугацаанд нь, 58 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 25,462.0 мянган төгрөгийн зөрчилд 10,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэнийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

2010-2013 онуудад үүссэн он дамжсан нийт 11,891.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй. Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8. “ер, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер

Аудитын менежер

Бэлтгэсэн:

“Лидер экаунт аудит” ХХК-ийн

Захирал

Ахлах аудитор



Ц.Бат-Өлзий

А.Цогбаяр



П.Шаравхорол

Д.Лхамсүрэн

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>2018.12.31</u>	<u>2019.12.31</u>
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	286,985,260.00	83,032,018.41
Дансны авлага	954,160,285.00	1,058,884,019.98
Татвар, НДШ – ийн авлага	803,128.30	
Бусад авлага	36,216,250.00	16,961,250.00
Бараа материал	32,630,976.34	34,418,853.64
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	17,500,000.00	
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,328,295,899.64	1,193,296,142.03
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	120,672,317.83	93,194,419.61
Биет бус хөрөнгө	2,272,166.75	1,065,666.79
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	122,944,484.58	94,260,086.40
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,451,240,384.22	1,287,556,228.43
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	53,362,454.54	52,577,000.00
Цалингийн өглөг		
Татварын өр	80,800,229.12	99,576,375.07
НДШ - ийн өглөг		9,541,645.24
Банкны богино хугацаат зээл		
Бусад богино хугацаат өр		
Урьдчилж орсон орлого	500,000.00	
Бусад өглөг		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	134,662,683.66	161,695,020.31
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өглөг		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	134,662,683.66	161,695,020.31
Эздийн өмч		
Өмч: Төрийн	161,153,013.31	161,153,013.31
Хувийн		
Хувьцаат		
Халаасны хувьцаа		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	1,155,424,687.25	964,708,194.81
Эздийн өмчийн дүн	1,316,577,700.56	1,125,861,208.12
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,451,240,384.22	1,287,556,228.43

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>2018.12.31</u>	<u>2019.12.31</u>
Борлуулалтын орлого (цэвэр)	1,571,211,129.09	1,054,051,027.28
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	538,114,785.90	357,562,108.47
Нийт ашиг (алдагдал)	1,033,096,343.19	696,488,918.81
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	19,374,456.31	2,466,136.16
Бусад орлого		1,818,181.82
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	1,006,478,683.85	875,689,417.04
Санхүүгийн зардал		
Бусад зардал	478,730.99	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(3,506,929.71)	(1,723,101.86)
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	42,006,454.95	(176,639,282.11)
Орлогын татварын зардал	14,345,261.55	246,613.61
Татвар дараах ашиг (алдагдал)	27,661,193.40	(176,885,895.72)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	27,661,193.40	(176,885,895.72)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	27,661,193.40	(176,885,895.72)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	161,153,013.31						1,324,337,227.85	1,485,490,241.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(196,573,734.00)	(196,573,734.00)
Залруулсан үлдэгдэл								
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							27,661,193.40	27,661,193.40
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	161,153,013.31						1,155,424,687.25	1,316,577,700.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
Залруулсан үлдэгдэл								
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(176,885,895.72)	(176,885,895.72)
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг							(13,830,596.72)	(13,830,596.72)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	161,153,013.31						964,708,194.81	1,125,861,208.12

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөг/	
<u>Үзүүлэлт</u>	<u>2018.12.31</u>	<u>2019.12.31</u>
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,541,610,417.80	1,109,907,193.33
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	701,318,100.00	457,252,157.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	11,450,189.00	10,281,623.00
Буцаан авсан албан татвар		
Бусад мөнгөн орлого	828,842,128.80	642,373,413.33
Мөнгөн зарлагын дүн	1,756,057,639.33	1,298,300,334.04
Ажиллагчдад төлсөн	408,402,807.87	466,994,075.35
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	106,254,401.18	122,065,129.61
Бараа материал худалдан авахад төлсөн	14,960,500.00	26,493,800.00
Ашиглалтын зардалд төлсөн	19,519,314.00	36,465,233.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		15,889,000.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	141,659,895.95	114,314,387.62
Даатгалын төлбөрт төлсөн	22,220,009.96	617,112.00
Бусад мөнгөн зарлага	1,043,040,710.37	515,461,596.46
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(214,447,221.53)	(188,393,140.71)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	59,374,456.31	2,466,136.16
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	40,000,000.00	
Хүлээн авсан ноогдол ашиг		
Хүлээн авсан хүүний орлого	19,374,456.31	2,466,136.16
Мөнгөн зарлагын дүн	14,668,800.00	5,528,700.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	14,668,800.00	5,528,700.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	44,705,656.31	(3,062,563.84)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
Мөнгөн зарлагын дүн	61,869,488.00	12,497,537.04
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
Төлсөн ногдол ашиг	61,869,488.00	12,497,537.04
Бусдад олгосон зээл		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,869,488.00)	(12,497,537.04)
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(231,611,053.22)	(203,953,241.59)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	518,596,313.22	286,985,260.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	286,985,260.00	83,032,018.41